

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭЖ БАЙГАА ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

2022.10.21.

Чойр хот

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн яамны санхүү, төсвийн судалгааны газрын дарга, төслийн захирагчийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний удирдамж”, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/57 дугаар захирамжийг тус тус эрх зүйн үндэс болгоно.

Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлд олон нийтийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэсэн. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 2022 оны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд олон нийтийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж байгаа иргэд болон хяналтын бүлгийн гишүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй эзэмшүүлэх.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, олон нийтийн оролцоог хангах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ

1. Анкетын болон санал асуулга, баримт нотолгоо, бичиг баримтанд анализ, дүгнэлт хийх аргаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төлөвлөлт, гүйцэтгэлийн бичиг баримтын эх хувь, ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн систем, шилэн данс, цахим хуудас, санал асуулга зэргийг ашиглав.

ШИВЭЭГОВЬ СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Шивээговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө саналыг 1 дүгээр багийн 359 иргэнээс цаасаар, 78 иргэнээс цахимаар 2 дугаар багийн 234 иргэнээс цаасаар, 8 иргэнээс цахимаар нийт 679 иргэдээс буюу сумын нийт өрхийн 64,6 хувиас Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр

хавсралт маягтын дагуу цаасаар болон цахимаар авч урьдчилсан жагсаалтыг боловсруулж, ИНТХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлсэн байна. Урьдчилсан жагсаалтын иргэдийн саналын тоо саналын хуудасны тоотой зөрсөн байна.

Багийн Засаг дарга нар ИНТХ-ын тогтоол болон хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийн танилцуулгыг 2021 оны 5 дугаар сарын 31-ний дотор албан бичгээр сумын Засаг даргад хугацаанд нь хүргүүлсэн байна.

Шивээговь сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/23 дугаар "Төсөл арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийг байгуулах тухай" захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилон 6 дугаар сард ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж 2 багийн ИНТХ-аар хэлэлцүүлсэн 32 саналыг нэгтгэн хосын аргаар эрэмбэлсэн байна.

Бодлогын баримт бичиг болон сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан Засаг даргын чиг үүрэгт хамааралтай 22 хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг сумын 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр, Улс болон аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамааралтай 11 арга хэмжээг аймгийн Засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

Шивээговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд нийт 682.699,4 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, тухайн жилд санхүүжүүлэх төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 10 дугаар тогтоолоор баталсан байна.

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь бодлогын баримт бичиг болон сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.1 дэх заалтыг хангасан байна.

2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад эрэмбэлэгдээгүй "Иргэний танхимын засвар"-ын ажил, бохирын шугамын бөглөө гаргах, засварлах ажлуудыг батлуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.2 дахь заалтыг зөрчсөн байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг ил тод мэдээлсэн эсэх:

Тендер сонгон шалгаруулалтыг www.tender.gov.mn цахим системд оруулсан, тендерийн урилга, худалдан авах ажиллагааны үр дүнг цахим хуудас, өдрийн сонинд нийтэлж иргэд олон нийтэд хүргэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог хуульд заасны дагуу байгуулсан эсэх:

Үнэлгээний хороонд иргэний төлөөллийг оруулж, гишүүд мэдэгдэх хуудсыг хууль, журмын дагуу хугацаанд бөглөсөн байна.

Тендер шалгаруулалт хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх:

Сумын 2022 оны ОНХС-ийн 512,091.2 мянган төгрөгөөр 5 тендер, 40,000.0 мянган төгрөгийн 2 бараа, 77,073.1 мянган төгрөгийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 10 дугаар сарын байдлаар 473,436.6 мянган төгрөгөөр 4 тендер, 20,000.0 мянган төгрөгийн 1 бараа, 5,000.0 мянган төгрөгийн 1 арга хэмжээг хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр 6 ажлаас 4 ажилд нь иргэний хөндлөнгийн хяналт хийлгэж хяналтын хуудсыг бөглүүлсэн байна.

Тендер шалгаруулалтын үйл ажиллагааны баримтыг хянаж үзээд төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг шалгаруулахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

ОНХС-ийн удирдлагын системд төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайлагналтыг бүрэн шивж оруулсан эсэх:

ОНХС-ын хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, санхүүжилтийг ОНХС-ын удирдлагын мэдээллийн системд бүртгэлийг тухай бүр байршуулсан боловч төслийн нэршлийг буруу шивсэн болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээг бүрэн шивээгүй байна. Үүнд:

- ✓ Сумын нийтийн эзэмшлийн гадна инженерийн шугам сүлжээний цэвэр усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажил.
- ✓ 2023 онд хийгдэх ажлуудын зураг төсөв боловсруулах
- ✓ Мал, аж ахуйн арга хэмжээний зардал
- ✓ Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал

**ИРГЭД, ХЯНАЛТЫН БҮЛГИЙН ОРОЛЦООТОЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ЗӨВЛӨМЖИЙН НЭГТГЭЛ**

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж байгаа иргэд болон хяналтын бүлгийн гишүүдийн 8 иргэнтэй хамт 2022 оны ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хамтран хийж дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэнг чадавхжуулж тогтвор суурьшилтай ажиллуулах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.
3. Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 160 дугаар тогтоолоор

батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам", Сангийн сайдын 102 дүгээр "Журам шинэчлэн батлах тухай" тушаал, 103 дугаар "Журам батлах тухай" тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.

4. Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Хяналт-Шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх.

ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

1. Сумын ИТХ-ын тогтоолоор томилогдсон "Хяналтын бүлэг"-г чанартай ажиллуулж хяналт хийсэн ажлын тайланг ажил тус бүрд гаргах, Засаг дарга, ЗДТГ-т зөвлөмж хүргүүлж ажиллах.

2. Хяналтын бүлгийн хяналт хийсэн ажлын тайланг цахим хуудас болон бусад мэдээ, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төслийг эрэмбэлээгүй арга хэмжээг батлахгүй байхад анхаарах.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг аймаг, сумын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан төлөвлөсөн эсэхэд хяналт тавих.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажил тус бүрд сумын Засаг даргын захирамжаар хөндлөнгийн хяналт тавих иргэдийг томилон ажиллуулж хяналтын хуудасны маягтын дагуу санал, дүгнэлтийг авч үйл ажиллагааг сайжруулах.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төслийг эрэмбэлээгүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.

3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сумын төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусган хэрэгжүүлэх.

4. Сумын Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг тухайн саналыг ирүүлсэн багын Засаг даргаар дамжуулан иргэдэд 2022 онд багтааж мэдээлэх ажлыг зохион байгуулах.

5. Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системд мэдээллүүдийг алдаагүй, үнэн бодитой хугацаанд нь оруулахад анхаарах. 2022 онд хийгдсэн ажлын тайланг бүрэн оруулах. Алдаатай оруулсан мэдээллүүдийг засварлах.

6. Багийн Засаг дарга нар урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ иргэдээс ирсэн саналын агуулгыг алдагдуулахгүйгээр утга найруулга, агуулгын хувьд зөв томъёолох, албаны үг хэллэгээр бичиж саналыг эрмбэлүүлэх, системд оруулах.

7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах. Хөрөнгө бий болсон тухай бүрд холбогдох байгууллагын данс бүртгэлд бүртгэх.

8. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг аймаг, сумын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх.

9. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үр дүнг байгууллагын цахим хуудас болон бусад мэдээ, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх.

ЗӨВЛӨМЖИЙГ ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА  Д.СОДНОМ

ЗӨВЛӨМЖИЙГ НЭТГЭСЭН:

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ  О.БОЛОРМАА